



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021-109-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2020 он

Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580

Цахим хаяг:

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716

Цахим хаяг:

Ахлах аудитор: П.Мөнхтуяа

Утас: 70342716

Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХАК	Хувийн аудитын компани

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	3
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	3
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	3
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	3
3. Аудитын тайлан.....	17
3.1. Ерөнхий зүйл.....	17
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	18
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	18
3.4. Материаллаг байдал	19
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	19
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	20
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	21
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
3.9. Аудитын илрүүлэлт.....	22
Залруулсан алдаа.....	22
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	22
Аудитын зөвлөмж.....	23
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	27
4. Менежментийн захидал.....	23
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	24

- 1.Төрийн аудитын санал, дүгнэлт**
 - 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**
 - 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**
 - 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**
 - 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**
 - 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**
 - 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**
 - 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**
-



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.08 № 33

танай _____ -ны № _____ т

АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ П.ОЮУНЦЭЦЭГ
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 9.1-д заасны дагуу Нэгдсэн эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нэгдсэн эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нэгдсэн эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

006020067

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>750,996,931.74</u>	<u>938,524,523.82</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,894,600.00	2,158,600.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	8,894,600.00	2,158,600.00
3121	Төгрөг	8,894,600.00	2,158,600.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	8,894,600.00	2,158,600.00
33	АВЛАГА	00.00	105,692.20
335	Бусад авлага	00.00	105,692.20
3351	Байгууллагаас авах авлага	00.00	105,692.20
35	БАРАА МАТЕРИАЛ	742,102,331.74	936,260,231.62
351	Түүхий эд материал	571,995,134.09	712,801,971.67
35110	Тусгай зориулалттай материал	496,515,913.97	522,011,184.97
35130	Эм боох материал	75,479,220.12	190,790,786.70
354	Хангамжийн материал	170,107,197.65	223,458,259.95
35410	Бичиг хэргийн материал	3,234,074.20	4,335,006.40
35420	Аж ахуйн материал	7,156,090.00	10,696,313.10
35430	Сэлбэг хэрэгсэл	55,000.00	55,000.00
35440	Түлш, шатах тослох материал	591,250.00	2,104,900.00
35450	Барилгын засварын материал	170,900.00	63,400.00
35460	Хүнсний материал	4,891,975.00	15,041,365.00
35470	Бусад хангамжийн материал	154,007,908.45	191,162,275.45
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,373,765,992.37</u>	<u>9,093,554,547.05</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,373,765,992.37	9,093,554,547.05
392	Биет хөрөнгө	6,082,002,658.97	8,834,540,380.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,718,152,277.57	5,755,757,492.57
39202	Хуримтлагдсан элэгдэл	-87,617,610.44	-126,272,212.81
39203	Авто-тээврийн хэрэгсэл	618,019,685.64	474,553,219.64
39204	Хуримтлагдсан элэгдэл	-264,022,073.59	-147,888,088.21
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	5,261,228,702.45	4,813,443,782.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,377,525,565.61	-2,329,730,460.26
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	436,301,696.70	515,671,573.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	-285,861,572.57	-171,345,355.44
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,000,000.00	3,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	44,365,199.08	44,365,199.08

Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,504,377.76	-2,182,830.52
39216	Дуусаагүй барилга, байгууламж	12,298,237.00	00.00
39217	Ном	5,168,060.50	5,168,060.50
393	Биет бус хөрөнгө	291,763,333.40	259,014,166.56
39301	Програм хангамж	25,455,120.00	10,880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-22,955,119.88	-112,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	330,280,000.00	330,280,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-41,016,666.72	-82,033,333.44
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>7,124,762,924.11</u>	<u>10,032,079,070.87</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>103,949,251.90</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	103,949,251.90
413	Өглөг	00.00	103,949,251.90
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	103,949,251.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>7,124,762,924.11</u>	<u>9,928,129,818.96</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	7,124,762,924.11	9,928,129,818.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,055,327,827.64	4,055,327,827.64
51101	Өмч: - төрийн	4,055,327,827.64	4,055,327,827.64
512	Хуримтлагдсан үр дүн	420,452,138.90	3,248,956,599.99
51210	Өмнөх үеийн үр дүн	420,452,138.90	445,589,705.13
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,803,366,894.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,648,982,957.57	2,623,845,391.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>7,124,762,924.11</u>	<u>10,032,079,070.87</u>

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,402,540,842.89	10,513,324,198.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	115,535,451.03	3,629,127,635.61
120	Нийтлэг татварын бус орлого	115,535,451.03	3,629,127,635.61
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	115,535,451.03	2,481,330,335.61
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,859,546.00	42,298,568.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,025,349.00	39,172,954.00
120009	Бусад орлого	00.00	1,147,797,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН	7,287,005,391.86	6,884,196,563.00

Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ОРЛОГО			
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,422,125,525.86	4,688,346,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,193,686,600.00	4,688,346,000.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	1,188,737,925.86	00.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	39,701,000.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	149,909,366.00	35,580,040.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,685,418.00	1,120,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	11,819,520.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000.00	18,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,218,500.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	71,185,928.00	16,460,040.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,714,970,500.00	2,160,270,523.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,714,970,500.00	2,160,270,523.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,809,067,505.97	7,709,957,303.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,809,067,505.97	7,709,957,303.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,789,779,481.68	7,704,998,799.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,582,615,715.50	4,281,633,389.50
210101	Үндсэн цалин	2,427,869,608.50	2,196,292,951.80
210102	Нэмэгдэл	818,484,044.00	1,631,699,949.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	139,134,000.00	150,051,000.00
210104	Урамшуулал	197,128,063.00	303,589,487.94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	442,309,481.01	527,716,553.31
210201	Тэтгэврийн даатгал	300,831,330.01	363,280,249.85
210202	Тэтгэмжийн даатгал	35,855,114.99	43,614,768.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	28,318,399.44	34,214,217.77
210204	Ажилгүйдлийн даатгал	6,589,167.74	7,857,427.89
210205	Эрүүл мэндийн даатгал	70,715,468.83	78,749,889.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	782,720,118.00	808,455,319.90
210301	Гэрэл, цахилгаан	63,169,418.00	73,297,396.90
210302	Түлш, халаалт	590,265,454.00	597,836,278.00
210303	Цэвэр, бохир ус	129,285,246.00	137,321,645.00
2104	Хангамж, бараа материалын зардал	93,190,239.46	119,881,149.62
210401	Бичиг хэрэг	6,104,987.80	5,512,765.80
210402	Тээвэр, шатахуун	50,070,727.50	45,464,109.00

Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,315,949.16	7,983,879.32
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	26,424,975.00	59,424,435.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,273,600.00	1,495,960.00
2105	Нормативт зардал	1,019,779,680.60	1,133,499,337.97
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	899,043,076.60	1,006,463,362.97
210502	Хоол, хүнс	105,567,966.00	114,713,255.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,168,638.00	12,322,720.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,078,810.00	48,271,878.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,519,600.00	17,672,768.00
210602	Тавилга	389,800.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	741,970.00	204,000.00
210604	Урсгал засвар	41,427,440.00	30,395,110.00
2107	Томилолт, зочны зардал	29,203,265.00	9,517,350.00
210702	Дотоод албан томилолт	29,203,265.00	9,517,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,599,603.00	32,445,325.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,145,402.00	14,200,168.70
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000.00	2,450,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,371,410.00	3,062,880.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	363,740.00	651,185.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176,000.00	123,200.00
210807	Газрын төлбөр	472,918.00	495,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	119,120.00	27,040.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,871,013.00	11,435,152.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	739,282,569.11	743,578,495.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	734,282,569.11	743,578,495.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,288,024.29	4,958,504.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,150,220.00	4,920,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,150,220.00	4,920,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,137,804.29	38,504.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,137,804.29	38,504.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>593,473,336.92</u>	<u>2,803,366,894.86</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>593,473,336.92</u>	<u>2,803,366,894.86</u>

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	6,118,360,258.00	6,977,108,468.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,793,792.00	81,843,492.00
120	Нийтлэг татварын бус орлого	59,793,792.00	81,843,492.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	59,793,792.00	81,843,492.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,859,546.00	42,298,568.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,934,246.00	39,544,924.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,058,566,466.00	6,895,264,976.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,193,686,600.00	4,688,346,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,193,686,600.00	4,688,346,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	149,909,366.00	46,648,453.30
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,685,418.00	1,120,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	11,819,520.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000.00	18,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,218,500.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	71,185,928.00	27,528,453.30
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,714,970,500.00	2,160,270,523.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,714,970,500.00	2,160,270,523.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	6,061,260,398.00	6,914,852,267.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,061,260,398.00	6,914,852,267.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,041,969,373.71	6,909,893,762.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,584,272,300.00	4,282,111,051.71
210101	Үндсэн цалин	2,114,007,900.00	2,197,644,541.94
210102	Нэмэгдэл	1,089,934,700.00	1,624,004,187.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	170,478,000.00	164,477,432.73
210104	Урамшуулал	209,851,700.00	295,984,889.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	442,309,481.01	527,716,553.30
210201	Тэтгэврийн даатгал	300,585,000.00	358,368,953.30

Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

210202	Тэтгэмжийн даатгал	35,830,300.00	42,336,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	28,318,399.44	38,139,600.46
210204	Ажилгүйдлийн даатгал	6,589,167.74	10,102,199.54
210205	Эрүүл мэндийн даатгал	70,986,613.83	78,768,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	782,720,118.00	808,455,319.90
210301	Гэрэл, цахилгаан	63,169,418.00	73,297,396.90
210302	Түлш, халаалт	590,265,454.00	597,836,278.00
210303	Цэвэр, бохир ус	129,285,246.00	137,321,645.00
2104	Хангамж, бараа материалын зардал	100,631,439.16	112,174,874.92
210401	Бичиг хэрэг	4,604,350.00	5,876,820.00
210402	Тээвэр, шатахуун	49,132,300.00	42,760,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,843,739.16	7,984,089.32
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,280,370.00	37,931,105.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,770,680.00	17,622,860.00
2105	Нормативт зардал	997,539,140.54	1,071,590,993.04
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	872,091,445.04	900,259,248.04
210502	Хоол, хүнс	100,101,195.50	124,862,645.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	25,346,500.00	46,469,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,991,540.00	64,273,930.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,680,470.00	20,284,100.00
210602	Тавилга	389,800.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,260,000.00	1,510,000.00
210604	Урсгал засвар	41,661,270.00	42,479,830.00
2107	Томилолт, зочны зардал	29,203,265.00	9,517,350.00
210702	Дотоод албан томилолт	29,203,265.00	9,517,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,302,090.00	34,053,690.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,145,402.00	13,006,645.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000.00	2,450,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,371,410.00	3,062,880.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	363,740.00	651,185.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176,000.00	123,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	2,576,000.00
210807	Газрын төлбөр	472,918.00	495,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	119,120.00	47,040.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	8,573,500.00	11,641,040.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	00.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,291,024.29	4,958,504.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,153,220.00	4,920,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,153,220.00	4,920,000.00

Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,137,804.29	38,504.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,137,804.29	38,504.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	57,099,860.00	62,256,201.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	48,205,260.00	68,992,201.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	48,205,260.00	68,992,201.00
2200	Дотоод эх үүсвэрээр	48,205,260.00	68,992,201.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	48,205,260.00	68,992,201.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-48,205,260.00	-68,992,201.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
14	Бусад эх үүсвэр	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	8,894,600.00	-6,736,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	8,894,600.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,894,600.00	2,158,600.00

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,725,047,827.64	2,649,271,122.13	603,999,806.10	00.00	6,978,318,755.87
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,725,047,827.64	2,649,271,122.13	603,999,806.10	00.00	6,978,318,755.87
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,055,327,827.64	2,648,982,957.57	420,452,138.90	00.00	7,124,762,924.11
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,055,327,827.64	2,648,982,957.57	420,452,138.90	00.00	7,124,762,924.11
D02	Нягтлан бодох бүртгэлийн	00.00	00.00	25,137,566.23	00.00	25,137,566.23

Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	бодлогын өөрчлөлт					
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,055,327,827.64	2,648,982,957.57	445,589,705.13	00.00	7,149,900,490.34
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-25,137,566.23	00.00	00.00	-25,137,566.23
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,803,366,894.86	00.00	2,803,366,894.86
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,055,327,827.64	2,623,845,391.33	3,248,956,599.99	00.00	9,928,129,818.96

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,968,161,700.00	5,966,526,087.71	7,111,080,700.00	6,929,428,082.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,968,161,700.00	5,966,526,087.71	7,111,080,700.00	6,929,428,082.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,956,291,700.00	5,954,656,867.71	7,106,160,700.00	6,924,508,082.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,568,782,100.00	3,568,782,100.00	4,288,889,200.00	4,275,747,451.71
210101	Үндсэн цалин	2,098,517,700.00	2,098,517,700.00	2,208,989,100.00	2,191,280,941.94
210102	Нэмэгдэл	1,089,934,700.00	1,089,934,700.00	1,582,888,700.00	1,624,004,187.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	170,478,000.00	170,478,000.00	173,943,000.00	164,477,432.73
210104	Урамшуулал	209,851,700.00	209,851,700.00	323,068,400.00	295,984,889.51
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	443,906,300.00	442,309,481.01	516,348,100.00	516,348,100.00
210201	Тэтгэврийн даатгал	300,585,000.00	300,585,000.00	347,000,500.00	347,000,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	35,830,300.00	35,830,300.00	42,336,900.00	42,336,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	28,664,300.00	28,318,399.44	33,869,500.00	38,139,600.46
210204	Ажилгүйдлийн даатгал	7,166,100.00	6,589,167.74	8,467,400.00	10,102,199.54

Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	71,660,600.00	70,986,613.83	84,673,800.00	78,768,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	782,722,600.00	782,720,118.00	816,229,200.00	808,455,319.90
210301	Гэрэл, цахилгаан	62,585,400.00	63,169,418.00	76,049,100.00	73,297,396.90
210302	Түлш, халаалт	590,266,000.00	590,265,454.00	602,869,500.00	597,836,278.00
210303	Цэвэр, бохир ус	129,871,200.00	129,285,246.00	137,310,600.00	137,321,645.00
210304	Байрны түрээс	00.00	00.00	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	102,901,400.00	102,901,339.16	120,017,900.00	120,017,874.92
210401	Бичиг хэрэг	4,770,000.00	4,516,950.00	5,770,000.00	5,474,420.00
210402	Тээвэр, шатахуун	47,907,600.00	47,907,600.00	51,312,100.00	42,760,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,845,000.00	8,843,739.16	8,057,000.00	7,984,089.32
210404	Ном, хэвлэл	00.00	00.00	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариугал	33,725,800.00	33,720,370.00	37,225,800.00	37,931,105.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,653,000.00	7,912,680.00	17,653,000.00	25,868,260.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00	00.00	00.00
2105	Нормативт зардал	982,279,500.00	982,276,394.54	1,227,248,800.00	1,069,552,166.04
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	856,828,700.00	856,828,699.04	1,055,097,600.00	898,220,421.04
210502	Хоол, хүнс	100,101,200.00	100,101,195.50	124,851,200.00	124,862,645.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	25,349,600.00	25,346,500.00	47,300,000.00	46,469,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,841,700.00	39,835,900.00	93,270,300.00	93,270,230.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,331,700.00	14,356,270.00	52,261,700.00	52,153,600.00
210602	Тавилга	10,000,000.00	10,000,000.00	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,510,000.00	1,510,000.00	1,510,000.00	1,510,000.00
210604	Урсгал засвар	14,000,000.00	13,969,630.00	39,498,600.00	39,606,630.00
2107	Томилолт, зочны зардал	12,500,000.00	12,499,900.00	12,500,000.00	9,517,350.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	12,500,000.00	12,499,900.00	12,500,000.00	9,517,350.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,358,100.00	18,931,635.00	31,657,200.00	31,599,590.00

Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,200,000.00	4,774,947.00	6,200,000.00	6,152,545.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000.00	1,080,000.00	2,450,300.00	2,450,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,371,500.00	3,371,410.00	3,062,900.00	3,062,880.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	364,100.00	363,740.00	651,200.00	651,185.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176,000.00	176,000.00	123,200.00	123,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00	6,976,000.00	6,976,000.00
210807	Газрын төлбөр	473,000.00	472,918.00	495,400.00	495,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	120,000.00	119,120.00	55,800.00	47,040.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	8,573,500.00	8,573,500.00	11,642,400.00	11,641,040.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5000000.00	5000000.00	0.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11870000.00	11869220.00	4920000.00	4920000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00	00.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00	00.00	00.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00.00	00.00	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,870,000.00	11,869,220.00	4,920,000.00	4,920,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,870,000.00	11,869,220.00	4,920,000.00	4,920,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00	00.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,968,161,700.00	5,966,526,087.71	7,111,080,800.00	6,929,428,082.57
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,193,686,600.00	4,191,761,795.71	4,688,346,000.00	4,688,307,495.57
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,193,686,600.00	4,191,761,795.71	4,688,346,000.00	4,688,307,495.57
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,714,970,500.00	1,714,970,500.00	2,320,055,600.00	2,160,270,523.00

Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	00.00	00.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,714,970,500.00	1,714,970,500.00	2,320,055,600.00	2,160,270,523.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	00.00	00.00	00.00	00.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	59,504,600.00	59,793,792.00	102,679,200.00	80,850,064.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,504,600.00	31,859,546.00	102,679,200.00	42,298,568.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	27,934,246.00	00.00	38,551,496.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	00.00	00.00	00.00	00.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	00.00	00.00	00.00	00.00
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	00.00	00.00	00.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	00.00	00.00	00.00
122002	Хандив тусламж /гадаад/	00.00	00.00	00.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	00.00	00.00	251.00	251.00
620001	Удирдах ажилтан	00.00	00.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	00.00	190.00	190.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	60.00	60.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00	00.00	00.00
632001	Төрийн өмчит МСҮТ	00.00	00.00	00.00	00.00
632002	Хувийн МСҮТ	00.00	00.00	00.00	00.00

Булган Нэгдсэн эмнэлэг

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2020 он 12 сар 31 өдөр

төгрөгөөр

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
1. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		46648453.3	-46648453.3	
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		46648453.3	-46648453.3	

Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Бараа үйлчилгээний зардал		46648453.3	-46648453.3	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		6363600	-6363600	
Үндсэн цалин		6363600	-6363600	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		11368453.3	-11368453.3	
Тэтгэврийн даатгал		11368453.3	-11368453.3	
Хангамж, бараа материалын зардал		1728700	-1728700	
Бичиг хэрэг		402400	-402400	
Бага үнэтэй түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс		1326300	-1326300	
Нормативт зардал		9796400	-9796400	
Эм бэлдмэл эмнэлэгийн хэрэгсэл		9796400	-9796400	
Эд хогшил худалдан авах		17273200	-17273200	
Багаж, техник хэрэгсэл		14400000	-14400000	
Урсгал засвар		2873200	-2873200	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр		118100	-118100	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж		118100	-118100	
ЗАРДЛЫН САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		46648453.3	-46648453.3	
Нэмэлт санхүүжилтын орлого		46648453.3	-46648453.3	
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1120000	-1120000	
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		18000000	-18000000	
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		27528453.3	-27528453.3	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
АЖИЛЛАГСДЫН ТОО	251	248	3	98.8
Удирдах ажилтан	1	1		100
Гүйцэтгэх ажилтан	190	187	3	98.4
Үйлчлэх ажилтан	60	60		100
СУРАЛЦАГЧДИЙН ТОО /жилийн дунджаар				
ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО				

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Оюунцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл,

анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймгийн Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Нэгдсэн эмнэлэг нь тайлант хугацаанд үйлчлүүлэгчийг эрхэмлэн, эерэг хандлагыг дээдэлж, чанартай аюулгүй лавлагаат тусламж үйлчилгээг үзүүлнэ гэж зорилго тавьсан байна. Үүний хүрээнд хэд хэдэн зорилтуудыг тавьжээ. Үүнд:

1. Нийгмийн эрүүл мэндийн олон талт арга хэмжээг хэрэгжүүлж эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх.
2. Эмч, эмнэлгийн ажилтны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.
3. Сувилагч, эх баригч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн үйл ажиллагааг дэмжих.
4. Эх, хүүхдийн болон эмнэлгийн эмнэлгийн тусламж үйлчилгээний эрсдэлийг бууруулан, аюулгүй байдлыг хангаж, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах.
5. Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын зэргийг дээшлүүлнэ гэсэн 5 зорилтыг тавьж ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй гэж үзэж байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

ХАК нь 2020 онд Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд баталгаажуулах аудит хийж, нийт 60919.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 9335.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 51584.1 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн байна.

Зөвлөмжийн хариуг хугацаанд ирүүлж ажилласан байна.

ХАК нь 2019 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчил илрээгүй мэдээллийг бүрэн мэдээлсэн гэж менежментийн захидалд дурдсан байна.

ХАК нь эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 3704004.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 74080.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон төлөвлөж гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 7709596.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 154191.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон авч үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нэгдсэн эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2907676.5 мянган төгрөгөөр буюу 29 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	742103.3	936260.2	194156.9
Үндсэн хөрөнгө	6373765.9	9093914.9	272014.9
Нийт хөрөнгө	7124762.9	10032439.4	2907676.5
Өр төлбөр		103949.2	103949.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7124762.9	9928490.2	2803727.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7124762.9	10032439.4	2907676.5

Мөнгөн хөрөнгө дансанд 2158.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан нь ахмадын дансны үлдэгдэл байна.

Авлага данс эхний үлдэгдэлгүй, оны эцэст байгууллагаас авах 105.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнажээ.

Бараа материалын дансны эцсийн 936260.2 үлдэгдэл мянган төгрөг болж 194156.9 мянган төгрөгөөр өссөн нь хандив тусламжаар 140167.0, төсвийн хөрөнгөөр 1353156.7 мянган төгрөгийн материал худалдан авч зарцуулсантай холбон үзэж байна.

Тухайн жил төсвийн хөрөнгөөр 1353156.7, өөрийн хөрөнгөөр 2912.4, ЭМГ-аас 97759.9, бусад эм хангамж болон иргэнээс 42407.1 төгрөгийн нийт 1494139.8 мянган төгрөгийн орлогыг материалын орлогод бүртгэн тайлагнажээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 11953119.3 мянган төгрөг болж 2700149.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 56904.6, хандив тусламжаар 2257898.7 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр элэгдлээ бүрэн нөхсөн авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, программ хангамж гэсэн үндсэн хөрөнгийг 1147797.3 мянган төгрөгөөр дахин үнэлж тайлагнасан байна.

Өр төлбөр данс үлдэгдлийг 103949.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж өглөгтэй тайлагнасан нь ковид цар тахлын үеэр эмнэлгийн урсгалыг бууруулж төлөвлөгөөт хагалгааг зогсоож, хэвтэн эмчлүүлэгчийн тасгийн орыг цөөрүүлсэн, мөн бэлэн байдлыг хангахад үндсэн үйл ажиллагааны зардлаас зарцуулсан, үзүүлсэн тусламж үйлчилгээ нь эмчийн алдаа болон алдаатай гүйлгээ зэргээс шалтгаалсан гэж үзэж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл нэмэгдэж хасагдсан хөрөнгөгүй байна.

Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1962986.1 мянган төгрөгөөр буюу 21 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь хандив тусламжийн бараа, материалын болон үндсэн хөрөнгө нэмэгдүүлсэн дүнгийн өөрчлөлт байна.

Үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 900529.4 мянган төгрөгөөр буюу 11.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалингийн зардал нэмэгдсэнтэй холбон үзэж байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оноос дахин үнэлгээний 1145654.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт гарч нягтлан бодох бүртгэл, стандартын дагуу бүртгэж тайлагнасан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4638346.0, өөрийн орлогыг 102679.2, ЭМДСангаас 2320055.5 буюу нийт 7061080.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн санхүүжилтэд 2020 оны 12 сард тодотгол орж 50000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь улсын төсвөөс санхүүжих санхүүжилтийг нэмэгдүүлжээ.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулах санхүүжүүлэхээр 7111080.7 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 4688346.0, ЭМДСангаас 2160270.5, ОНХС-гаас 18000.0, туслах үйл ажиллагааны орлогоос 39544.9, үндсэн үйл ажиллагааны орлогоос 42298.6, нэмэлт санхүүжилтээр 27528.4, иргэдээс 1120.0 мянган төгрөг буюу нийт 6977108.5 мянган төгрөгийн санхүүжилт авснаас гүйцэтгэлээр 6974911.4 мянган төгрөгийг зарцуулж 38.5 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэн ахмадын сангийн дансанд 2158.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ажиллажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6974911.4 мянган төгрөг буюу 99.9 хувьтай зарцуулж батлагдсан санхүүжилтийг бүрэн хэмжээнд зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Улсын/орон нутгийн/төсөвт төвлөрүүлэх орлого

Өөрийн орлогыг 102679.2 мянган төгрөгөөр төлөвлөн батлуулж гүйцэтгэлээр 81763.5 мянган төгрөгийн орлого оруулж орлогын биелэлт 79 хувьтай байна. Орлогын биелэлт 21 хувь буюу 20915.7 мянган төгрөгөөр тасарсан нь ковидтой холбогдуулж хэвтэн эмчлүүлэгчийн ор хоног болон урьдчилан сэргийлэгчдийн тоо цөөрсөнтэй холбон үзэж байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансны санхүүжилтээр 46648.4 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр бүрэн зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс тухай бүр мэдээлэх мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлсэн боловч тушаал шийдвэртэй холбоотой 2 мэдээллийг мэдээлээгүй байна.

Цаашид шилэн дансанд мэдээлэх бүх мэдээллийг цаг хугацаанд бүрэн мэдээлж ажиллахыг зөвлөж ажиллалаа.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 9335.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг биелүүлсэн байна.

Аудитаар өгсөн 51584.1 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилтийн хариуг албан тоот болон хэрэгжүүлж ажилласныг тайлангаар ирүүлж ажиллажээ.

нийт 60919.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 9335.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 51584.1 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0			
Албан шаардлага	2	9335.6	2	9335.6			
Зөвлөмж	5	51584.1	5	51584.1			
Нийт дүн	7	60919.7	7	60919.7			

Өмнөх оны зөвлөмжийн хариуг нөхөж 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 01/306 тоот албан бичгээр тайланг хавсарган хүргүүлсэн байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 156527.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1766.0 мянган төгрөгийн зөрчилд 4 акт тогтоож, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 154761.3 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгч ажиллалаа.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоотой залруулгын алдаа илрээгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 1766.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэнд 4 төлбөрийн акт тогтоож хүргүүлж ажиллалаа. Үүнд:

1. Томилолтын зардлыг олгохдоо 2 ажилтанд тус бүр нэг өдрийн томилолтын зардлыг 32000 төгрөгөөр илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохисгүй удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

2. Цалингийн зардал болон ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг олгохдоо сул орон тооны батлагдсан үндсэн цалингаас ажил хавсарсны нэмэгдлийг 40 хувиар олгоогүй, 60 хувиар тооцож 399196 төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохисгүй удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоолоор баталсан Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмын 2 дугаар 2.4-т “Төрийн албаны тухай хуулийн 3.1.4-т тодорхойлсон сул орон тооны албан үүргийг түр орлон гүйцэтгэх тохиолдолд тухайн албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг түр орлон гүйцэтгэсэн хугацаагаар тооцож олгоно. Албан үүргийг тор орлон гүйцэтгэгчийн үндсэн цалин, сул орон тооны албан тушаалын үндсэн цалинтай адил буюу түүнээс бага байх тохиолдолд энэ журмын 2.2-т заасныг баримтална” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

3. Эрүүл мэндийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/392 тоот тушаалыг үндэслэн 2020 оны хагас жилийн санхүү, гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж тайлагнасан гэж санхүү бүртгэлийн ажилтнуудад балансын урамшуулал олгох тухай байгууллагын даргын 2020 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн Б/243 тоот тушаалын хавсралтаар баталсныг үндэслэж ерөнхий санхүүчид 2 сарын, тооцооны нягтлан бодогчид 1.5 сарын, үндсэн хөрөнгө, цалин хариуцсан тооцооны нягтлан бодогчид 1 сарын, 2 няравт 0.5 сараар тус тус үндсэн цалингаас тооцон олгосныг тулгахад ерөнхий санхүүчид 0.5 сараар буюу 467449 төгрөгөөр урамшуулал илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-т “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох.”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 1.2-т “Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр

дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараахь эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно.”, мөн 3.3-т “Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгоно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлсэн нь:

Төлбөрийн акт тогтоож хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар батлагдсан орон тоо болон цалингийн санг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ

Тухайн байгууллага нь орон тоо болон ажилчдыг сэлгэн ажиллуулах нь их учраас анхаарал татахуйц байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Жилийн эцсийн үндсэн хөрөнгийн болон бараа материалын тооллого явуулсан гэх боловч тооллогын комиссын тайлагнасан тавилга эд хогшлын дүнг 37600.0, программ хангамжийн дүнг 1600.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байна..

1.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй.

1.3. Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 12.1 “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.” заалтын дагуу байгууллагын хөрөнгийн тооллогыг чанартай үр дүнтэй явуулж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийг дахин үнэлж санхүүгийн тайланд тусгахаар ирснээс тасаг нэгжийн тооллогын бүртгэлд хуучин үнээр үнийн дүнг тайлагнасан. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Дотоод асуудалтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг түүвэрлэн шалгахад шинэ жилийн баяртай холбогдуулан гарсан 438.0 мянган төгрөгийг зарцуулахдаа байгууллагын дотоод журмын заалтыг үндэслэн тушаал гаргасан нь үндэслэлгүй заалтаар тушаал шийдвэр гаргаж зарцуулсан байна.

2.2 Эрсдэл: Төсөв хүрэлцэхгүй өр авлага нэмэгдэх.

2.3 Өгсөн зөвлөмж: Тушаал шийдвэр төлөвлөхдөө холбогдох хууль, журам, дотоод журмын заалтыг баримталж ажиллах.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Шийдвэр гаргасан эрх зүйн үндэслэл болох хөдөлмөрийн дотоод журамд цаашид нэмж тусган ажиллах болно. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Авлага, өглөгтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Өмнөх оноос авлагыг 105.7 мянган төгрөгөөр, өглөгийг 103949.2 мянган төгрөгөөр тус нэмэгдүүлж ажилласан байна.

3.2 Эрсдэл: Төсөв хүрэлцэхгүй өр авлага нэмэгдэх.

3.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохисгүй удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Тайланд онд өр авлагыг нэмэгдүүлэхгүй, шат дараалалтай барагдуулж ажиллана.

4. Төсөв төлөвлөхдөө холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: Өмнөх оны шалгалтаар тавигдсан 11068.4 мянган төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулж байгууллагын нэмэлт дансанд төвлөрүүлж ажилласан ч уг төлбөрийн актын мөнгийг НДШ-ийн зардалд шилжүүлсэн байна.

4.2 Эрсдэл: Төсөв хүрэлцэхгүй өр авлага нэмэгдэх.

4.3 Өгсөн зөвлөмж: Төсөв төлөвлөхдөө бодит зардалд тулгуурлан төлөвлөж зардлыг зориулалтын дагуу зарцуулж ажиллах.

4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: 2018 онд давж орсон орлогыг 14 тасаг нэгжийн нийгмийн асуудал шийдвэрлэн олгосон 11068.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тавигдсанаас орсон орлогыг ажил олгогчийн НДШ-ийн зардлын өрийг барагдуулсан. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 05-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Аймгийн Нэгдсэн эмнэлэг	Аудитын код:
2020			САГ-2021/109/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Булган аймаг дахь Төрийн аудитын газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны
---	---------------------------	------------	---------------------------------------	---

Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Томилолтын зардлыг олгохдоо 2 ажилтанд тус бүр нэг өдрийн томилолтын зардлыг илүү олгосон	32.0	Төлбөрийн акт	Ерөнхий нягтлан бодогч	И.Энхжаргал
2	Цалингийн зардал болон ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг олгохдоо сул орон тооны батлагдсан үндсэн цалингаас ажил хавсарсны нэмэгдлийг 40 хувиар олгоогүй, 60 хувиар тооцож олгосон.	399.2	Төлбөрийн акт	Ерөнхий нягтлан бодогч	И.Энхжаргал
3	Балансийн урамшуулал олгохдоо 0.5 сараар илүү олгосон.	467.4	Төлбөрийн акт	Ерөнхий нягтлан бодогч	И.Энхжаргал
4	Жилийн эцсийн үндсэн хөрөнгийн болон бараа материалын тооллого явуулсан гэх боловч тооллогын комиссын тайлагнасан тавилга эд хогшлын дүнг, программ хангамжийн дүнг тус тус зөрүүтэй тайлагнасан байна.	39200.0	Зөвлөмж хүргүүлэх	Ерөнхий нягтлан бодогч	И.Энхжаргал
5	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг түүвэрлэн шалгахад шинэ жилийн баяртай холбогдуулан гарах зардлыг зарцуулахдаа байгууллагын дотоод журмын заалтыг үндэслэн тушаал гаргасан нь үндэслэлгүй заалтаар тушаал шийдвэр гаргаж зарцуулсан байна.	438.0	Зөвлөмж хүргүүлэх	Ерөнхий нягтлан бодогч	И.Энхжаргал
6	Авлага, өглөгийг нэмэгдүүлсэн.	104054.9	Зөвлөмж хүргүүлэх	Ерөнхий нягтлан бодогч	И.Энхжаргал
7	НДШ-ийг дутуу төлөвлөсөн.	11068.4	Зөвлөмж хүргүүлэх	Ерөнхий нягтлан бодогч	И.Энхжаргал
ДҮН		155659.9			

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН:
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР
 МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:
 АХЛАХ АУДИТОР П.МӨНХТУЯА